

ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН АМЛАЛТЫГ НОГООН ӨРИЙН СВОПООР САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОМЖМИЙН СУДАЛГАА

Б.Мөнхзул[†], Д.Түвшинжаргал[‡]

Хураангуй: Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал биднээс хол зүйл байхаа больсон гэдгийг 2022 оны баруун таван аймгийг хамарсан ган, 2023 оны 7 сард Улаанбаатар хотод болсон үерийн гамшиг, 2023 оноос 2024 оны өвлийн нийт газар нутгийн 90 хувийг хамарсан зудын гамшиг сануулж байна. Монгол улс Парисын хэлэлцээрт нэгдэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний амлалт өгсөн. Гэтэл засгийн газрын боловсруулсан зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа хэт гадны эх үүсвэр, донор байгууллагын санхүүжилтэд найдсан, дотоодын эх үүсвэр, бусад улсын сайн туршлагыг судлах, хэрэгжүүлэх дээр идэвх, санаачилга дутмаг байна. Энэхүү судалгааны ажлаар Монгол улс уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хүрээнд дэвшүүлсэн арга хэмжээг ногоон өрийн своп хэлцлээр санхүүжүүлэх боломжийг судаллаа. Бидний ногоон өрийн своп гэж өргөн утгаар тодорхойлсон хэлцэл нь нэг талаас зээлдүүлэгч тал өрийг хэсэгчлэн болон бүхэлд чөлөөлөх, үүнийг хариуд зээлдэгч тал байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх улс орнууд нэгдсэн зорилт, үйл ажиллагааг санхүүжүүлэх амлалт өгдөг санхүүгийн механизм юм. Энэ өрийн своп нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөний эрсдэл өндөртэй, тэр хэрээр нөлөөг бууруулах, дасан зохицох төсөл, арга хэмжээнд санхүүжилт хийх шаардлагатай хэдий ч гадаад өрийн өндөр түвшнээс шалтгаалан төсвийн орон зай хязгаарлагдмал хөгжиж буй орнуудыг хувьд тохирох механизм болдог байна. Судалгааны үр дүнд Монгол улсын засгийн газрын Парисын клубт харьяалагддаг улс орнуудаас авсан гадаад өрийг багцлан ногоон өрийн своп хэлцэл байгуулах тохиолдолд 5.1 их наяд төгрөг хүртэл; БНХАУ-аас авсан гадаад өрөөр уг хэлцлийг байгуулвал 6.5 их наяд төгрөг хүртэл; Монгол улсын засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан бондыг хямдруулан худалдан авах замаар ногоон өрийн своп хэлцэл байгуулвал 2.9 их наяд төгрөг хүртэл хэмжээний ногоон санхүүжилтийг тус тус босгох боломжтой гэдэг нь харагдлаа. Мөн ногоон өрийн своп хэлцэл байгуулснаар төрийн гадаад өрийн хэмжээг 27 хүртэл хувиар бууруулах боломжтой бөгөөд энэ нь Монгол улсын макро эдийн засгийн орчныг сайжруулах нэг чухал үзүүлэлт болно гэж үзэж байна.

Түлхүүр үг: Өрийн своп хэлцэл, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт, ногоон санхүү, тогтвортой хөгжил

JEL ангилал: F34, H63, Q01, Q56

[†] Монголбанкны ахлах эдийн засагч, MBA, Утас: 89046335, 324006, Email: Munkhzul.b@mongolbank.mn,

[‡] СЭЗИС-ийн эдийн засгийн тэнхмийн эрхлэгч, Ph.D, Дэд профессор, Email: tuvshinjargal.d@ufe.edu.mn

I. Удиртгал

Монгол улс газар зүйн байрлал, уур амьсгалын онцлогоос шалтгаалан дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн өртөж буй орнуудын нэг гэдгийг 2000-2015 оны хооронд нийт нуур цөөрмийн 21%, гол мөрний 12%, горхи булгийн 15% нь хатаж ширгэсэн статистик нотолно. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр манай улсад хүчтэй салхи, цасан шуурга, аадар бороо, аянга цахилгаан, үер, ой хээрийн түймэр, ган, зуд зэрэг цаг агаарын аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 54 удаа тохиолдож, тэдгээрийн давтамж сүүлийн 20 жилд хоёр дахин нэмэгджээ (БОАЖЯ, 2020). Үүний тод жишээ бол 2022 оны баруун таван аймгийг хамарсан ган, 2023 оны 7 сард Улаанбаатар хотод болсон үерийн гамшиг, 2023 оноос 2024 оны өвлийн нийт газар нутгийн 90 хувийг хамарсан зудын гамшигт үзэгдэл юм. Уур амьсгалын өөрчлөлт дэлхийн өнцөг булан бүрд хурдацтай явагдаж байгаагаас шалтгаалан улс орнууд эдийн засгийн хөгжлийн загвараа эргэн харж, 2015 онд “Парисын хэлэлцээр” буюу уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх олон улсын гэрээг баталж, улс бүр үүрэг хүлээсэн. Манай улс энэ хэлэлцээрт нэгдэн 2030 онд хүртэл хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний амлалт өгсөн бөгөөд нийт 30.3 их наяд орчим төгрөгийн санхүүжилт шаардлагатай хэмээн тооцож, түүний 20%-ийг дотоодын эх үүсвэрээр, 80%-ийг гадаад эх үүсвэрээр бүрдүүлэхээр бичиг баримтад заажээ (БОАЖЯ, 2020). Гэтэл Дэлхийн байгаль хамгаалах сангаас боловсруулсан Монгол улсын уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бодлого, түүний хэрэгжилтэд хийсэн шинжилгээнд “Монгол улс уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагаанд түлхүү гадны эх үүсвэр, донор байгууллагын санхүүжилтийг ашиглах тухай дурдсан бөгөөд дотоодын эх үүсвэрээс босгох санхүүжилтийн хэмжээ, уг эх үүсвэрээ бүрдүүлэх талаар огт дурдаагүй” хэмээн шүүмжилсэн. Энэ шүүмжлэл болон 2023 оны үер, зудын эрсдэл засгийн газрыг Парисын хэлэлцээрийн биелэлтийг хангах амлалт, баримт бичигт туссан үйл ажиллагаа, төслийг гадаадын донор байгууллагын хандив, санхүүжилтэд найдан хүлээлгүй, дотоод нөөц боломжоо ашиглах, бусад улсын сайн туршлагыг судлах, хэрэгжүүлэх зэргээр идэвх, санаачлагтай ажиллахыг шаардаж байна.

Дан ганц Монгол улсын төдийгүй бусад бага болон дундаас доогуур орлоготой орнууд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн эрсдэл болон төсөв, өрийн дарамт гэсэн гурвалсан эрсдэлтэй хэдийн тулгарчээ (Steele & Patel, 2020). ОУВС-ийн судлаачид бага, дунд орлоготой 128 улсыг уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн түвшнээр хоёр бүлэгт хувааж, медианаас дээш хэсгийг харахад ихэнх орнууд 2021 оны байдлаар давхар төсвийн өндөр эрсдэлтэй байгааг тогтоосон (Chamon, Klok, Thakoor, & Zettelmeyer, 2022). Энэ нь ямар нэг учир шалтгааны хамаарлыг илэрхийлэхгүй хэдий ч нэг талаас өрийн асуудал нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах хөрөнгө оруулалт хийх төсвийн орон зайг бууруулж, нөлөөг хурцатгана. Ковид-19 цар тахал энэ хос эрсдэлийг улам хүндрүүлсэн. Улс орнуудын засгийн газрыг иргэдийн амьжиргаа, эрүүл мэндийг эн тэргүүнд хамгаалж, эдийн засгийн үйл ажиллагааг хумих, төсвийн алдагдал нэмэгдэх, гадаад өрийн нөхцөл байдлыг эрсдэлтэй түвшинд хүргэсэн. 2021 оны байдлаар 64 бага дунд орлоготой орны төсвийн орон зайг гадаад өрийн өнөөгийн өртгийн ДНБ-д эзлэх хувийг ОУВС-н тодорхойлсон өрийн эрсдэлийн босго түвшинтэй харьцуулж тооцсон судалгааны үр дүнгээс 33 улс ДНБ-ий 10 хувиас бага, 28 улс сөрөг төсвийн орон зайтай байна (Chamon, Klok, Thakoor, & Zettelmeyer, 2022).

Гадаад өрийн дарамтанд орсон болон өрийн эрсдэл өндөр орнуудын хувьд байгаль орчныг хамгаалах санхүүжилтийг босгох нэг боломжит арга зам бол ногоон өрийн своп юм. Тодруулбал уг хэлцэлд оролцогч нэг тал нь байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх гэх мэт улс орнууд нэгдсэн ойлголцолд хүрч, хамтран хэрэгжүүлж буй арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг амлалт авах бол нөгөө тал үүрэг амлалт авч буй талынхаа өрийг хэсэгчлэн болон бүхэлд нь чөлөөлдөг санхүүгийн механизм юм. Ийм бидний ногоон өрийн своп гэж тодорхойлсон ийм төрлийн хэлцлийг debt for nature swap, debt for climate swap буюу “байгаль орчны өрийн своп” эсвэл “уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх өрийн своп” гэж олон улсад нэрлэдэг. Өнгөрсөн хугацаанд зөвхөн байгаль орчныг хамгаалахад энэ төрлийн своп хэрэгслийг ашигладаг байсан бол уур

амьсгалын өөрчлөлттэй тэмцэх арга хэмжээ сүүлийн жилүүдэд эрчээ авч буйтай холбогдуулан уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чиглэсэн өрийг своп хэрэгслийг ашиглах тохиолдол 2015 оноос хойш нэмэгдэх хандлагатай байна. Үүний нэг илрэл бол 2023 оны сүүлд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын COP28 бага хуралд “Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чиглэсэн өрийн своп хэрэгсэл: Парисын хэлэлцээрийг хэрэгжилтийг дэмжих хэрэгсэл болох нь” сэдвээр тусгай хэлэлцүүлэг зохион байгуулсан байдаг (Мөнхзул, 2024).

Эдийн засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн байгууллага төв болон зүүн Европ, төв Азийн орнуудын 1990-ээд онд хэрэгжүүлсэн ногоон өрийн свопыг судалж, оролцогч талуудад олгох давуу тал, институцийн бүтэц, анхаарах асуудал, боломжит эрсдэлийг тодорхойлжээ. Энэ судалгааны үр дүнгээс харахад ногоон өрийн свопыг амжилттай хийснээр бага орлоготой орон макро эдийн засаг дахь хатуу валютаар төлөх өрийн үйлчилгээний төлбөрийн дарамтыг нимгэлэх; байгаль орчны асуудлыг шийдэх багагүй үнийн дүнтэй дээр нь тогтвортой санхүүжилтийг шийдэх зэрэг үр өгөөж хүртдэг байна. Харин бусад улс орнуудтай хуваалцах сургамжийг өрийн своп хийх гэж байгаа улсын засгийн газар зээлдүүлэгч талыг свопын хэлцэлд урих урьдач чухал нөхцөл нь эдийн засаг, төсвийн итгэлтэй амлалтыг бий болгох; Парисын клубын улс орнуудаас авсан өрийг своп хэлцлээр нөхцөлийг нь өөрчлөвөл илүү нааштай үр дүнд хүрэх боломжтой талаар дурджээ. Түүнчлэн ногоон өрийн своп хийх нь урт хугацааны амлалт учраас макро эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдалд мэдрэмтгий байх, свопоор бий болсон орлогыг буруу удирдах, байгаль орчны зорилт биелэхгүй байх зэрэг боломжит эрсдэл байхыг анхааруулжээ (OECD, 2007).


БНХАУ бол манай улс төдийгүй хөгжиж буй орнуудын хувьд хамгийн том зээлдүүлэгч улс юм. Дэлхийн банк, Бостоны Их сургуулийн судалгааны төвөөс гаргасан зарим статистик, тооцоог харвал 2020 онд Их 20-н орнуудаас санаачилсан өрийн үйлчилгээний төлбөрийг түр хойшлуулах санаачилга (DSSI)-т хүсэлт гаргасан Тонго (55%) тэргүүтэй 17 улсын цор ганц хамгийн том зээлдүүлэгч улс нь Хятад байв. Хятадын засгийн газраас “Бүс ба Зам” санаачлагын хүрээнд төрөл бүрийн замаар их хэмжээний зээл олгожээ. Гэтэл энэ санаачлагад нэгдсэн улс орнуудаас Ковид-19-н нөлөөгөөр гадаад өрийн эрсдэлтэй тулгарч, Хятад улстай өрийг хойшлуулах, бүтцийг өөрчлөх талаар хүсэлт илгээсэн байна. Yue ба Wang (2021) нар Хятадын хувьд ногоон өрийн своп амжилттай хийснээр зээлдэгч улстай эдийн засаг, улс төр, хүн хоорондын харилцааг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, дасан зохицох олон улсын нийтлэг зорилтыг хангахад их гүрний хүлээх үүргээ биелүүлсэн нэр хүндийг олж авах, зээлдэгч улс өрийн эрсдэлээс зайлсхийж чадсанаар гадаад дахь хөрөнгө оруулалтын аюулгүй байдал нэмэгдэх өгөөжтэй байхыг тодорхойлжээ. Харин Swanson ба Yue (2022) нар Хятадын хувьд ногоон өрийн своп хийх орнуудад нийтлэг хэдэн шаардлага тавих саналыг тавьсан. Тэдгээрт өр төлбөрийг хойшлуулах эсвэл төлбөрийн чадваргүй болох эрсдэл өндөртэй; хэлцэл байгуулсан тохиолдолд байгаль орчны эерэг өөрчлөлт гарах; өртэй улс засаглал сайн, дотоод улс төрийн тогтвортой орчинтой байх зэргийг багтаасан.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь ногоон өрийн своп хэлцэл ашиглан Монгол улсад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах зорилтыг хангах үйл ажиллагааны санхүүжилт бий болгох хийгээд өрийн дарамтыг бууруулах боломжийг судална. Судалгааны ажлын бүтцээс дурдвал, эхэлж ногоон өрийн свопын төрөл, хэлцэл хийснээр талуудын хүртэх өгөөж, сорилт, бодлогын арга замыг авч үзсэн. Улмаар Монгол улсын хувьд ногоон своп хэлцэл хийснээр гадаад өр буурах хийгээд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах зорилтын хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааг санхүүжүүлэх дотоод эх үүсвэрийн хувилбарыг гаргасан үр дүнгээ тайлбарласан. Эцэст нь судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэлт, санал өгсөн.

II. Ногоон өрийн свопын тухай ойлголт

1987 онд Болив улсын Ситигрупээс авсан 650,000 ам.долларын нэрлэсэн үнэтэй өрийг Conservation International ТББ хоёрдогч зах зээлээс 100,000 ам.доллаароор худалдан авчээ. Үүний дараа Conservation International Болив улсын засгийн газрыг 650,000 ам.долларын өрийн төлбөрөөс бүрэн чөлөөлж, хариуд нь Болив улсын нутаг дэвсгэр дэх Амазоны ширэнгэн ойн 4 сая акр газрыг хамгаалалтанд авах хэлэлцээр хийжээ. Энэ бол байгаль орчны өрийн своп (debt for nature swap) бөгөөд хөгжиж буй улс орнуудын гадаад өрийн үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх, чөлөөлсний хариуд зээлдэгч улс байгаль хамгаалах төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх, төсвөөс зохих санхүүжилт хийх үүрэг хүлээдэг. Энэ төрлийн свопыг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилгоор ашиглах тохиолдолд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх өрийн своп (debt for climate swap) гэж бас нэрлэдэг. Бид ногоон өрийн своп гэж өргөн утгаар нь судалгааны ажилдаа ашиглав. Ногоон өрийн свопыг оролцогч талуудын хүрэнээс хамааруулж хоёр талт болон олон талт гэж ангилдаг. Зөвхөн зээлдэгч болон зээлдүүлэгч талууд шууд хэлцэл хийх свопыг хоёр талт гэдэг. Харин олон зээлдүүлэгчийг хамруулах, байгаль орчны чиглэлийн ТББ гэх мэт олон талыг оролцуулсан хэлцлийг олон талт гэж нэрлэдэг (Зураг 1).

Зураг 1. Ногоон өрийн свопын үйл ажиллагааны схем, олон талт хэлцлийн жишээн дээр




Эх сурвалж: Б.Мөнхзул (2024)

Зээлдэгч орны засгийн газар, олон улсын төрийн бус байгууллага, шаардлагатай тохиолдолд хандивлагч болон хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгч тал, зээлдэгч улсад олгох санхүүжилт, хяналтыг хариуцах итгэлцлийн сан, олон тооны төслийн нэгж гэх мэт олон тал оролцдог.

1980-аад оны сүүл болон 1990-ээд онд ногоон өрийн свопыг өргөн ашигласан түүх нь Латин Америкийн улс орнууд өрийн хямралд орж, бүс нутгийн болон улс орны түвшинд ач холбогдолтой төсөл арга хэмжээнд санхүүжилт гаргахад хүндрэлтэй болсонтой холбогддог. Анх гадаад өрийн дарамт өндөртэй хөгжиж буй улс орнуудад байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор энэ өрийн хэрэгслийг ашигласан байна. Улмаар Латин Америкийн улс орнуудын өрийн дарамтын асуудал тодорхой хэмжээнд шийдэгдэж, 2000 оноос эхлэн дэлхий дахинд мөнгөний зөөлөн бодлого давамгайлж, санхүүжилтийн өртөг хямдарсан нь ногоон өрийн свопын эрэлтийг бууруулах хүчин зүйл болов (Зураг 2).

Зураг 2. 2015 он хүртэл байгуулсан байгаль орчны өрийн своп



Эх сурвалж: African Natural Resources Management and Investment Centre (2022)

Ногоон өрийн своп нь олон улс дамнасан шинжтэй байдгаас шалтгаалан хууль, эрх зүйн орчинд нийцүүлэх, эзэлдэгч улсын засаглал, хяналтын тогтолцооноос шалтгаалан байгаль орчныг хамгаалах төсөл амжилтгүй болох, макро эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан төслийн нийгэм, эдийн засгийн үр ашиг өөрчлөгдөх гэх мэт эрсдэлийг тооцох, бууруулахын тулд талууд олон удаагийн уулзалт, хэлэлцээр хийх, зөвлөх үйлчилгээ авах хэрэг гардаг. Түүнчлэн эзэлдэгч улсад хэрэгжих байгаль орчныг хамгаалах төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд эрх ашиг нь хөндөгдөх бүлэгтэй зөвшилцөлд хүрэх суурь нөхцөлийг бүрдүүлэх үүднээс иргэд олон нийтийн саналыг асуух, сурталчлан таниулах гэх мэт нөлөөллийн ажлууд олноор хийдгээс шалтгаалан цаг хугацаа, мөнгө санхүү ихээр шаарддаг. Тиймээс энэ төрлийн өрийн своп нь дараах сорилтуудтай тулгардаг. Үүнд:

- *Харьцангуй өндөр хэлцлийн зардалтай:* Своп хэлцэл байгуулах талаар олон шатны уулзалт, хэлэлцээр хийх, хэлцэл байгуулагдсаны дараа уг төслийг удирдах, хянах гэх мэт олон үе шаттай байдгаас шалтгаалан хэлцлийн зардал өндөр гардаг. Ялангуяа олон талт своп хэлцлийн хувьд хэлцэл байгуулах хугацаа урт, хэлцэл байгуулахад гарах зардал өндөр байх талтай. Зарим судалгаагаар энэ хугацаа хоёроос дөрвөн жил байна.
- *Урт хугацааны санхүүгийн амлалт.* Ногоон өрийн своп амжилттай хэрэгжих нь эзэлдүүлэгч улсын засгийн газар тохирсон байгаль орчны хөтөлбөрт төсвөөс санхүүжилтийг урт хугацаанд тогтвортой хийхээс хамаарна. Ийм амлалтыг өгөх төсвийн хүндрэл, авлига, засаглалын асуудлаас шалтгаалан хэцүү байдаг.
- *Валютын ханш унах, инфляцын асуудал.* Ногоон өрийн свопоор эзэлдэгч улсын засгийн газар байгаль хамгаалах итгэлцлийн санд үндэсний валютаар санхүүжилт хийх үүрэг хүлээдэг. Гэтэл тухайн улсын валютын ханш унах, өндөр инфляц амласан санхүүжилтийн бодит өртгийг бууруулах эрсдэл үүсгэдэг.


2020 оноос энэ свопын төрөл эргэж судлаач болон бодлого боловсруулагч нарын анхааралд орж ирсэн. Үүнд нэг талаар 2021 онд Белиз улс харьцангуй өндөр дүнтэй өрийг хувиргах своп хэлцэл хийж, өрийг бага хэмжээгээр бууруулдаг гэх түүний шүүмжлэлтэй талыг үгүй хийж, харьцангуй хэлцлийн зардлыг бууруулсан. Ингэснээр энэ өрийн своп нь гадаад өр болон байгаль орчны асуудлыг зэрэг шийдэх боломжийг олгох давуу талтай гэж судлаачид харах болсон. Энэ цаг хугацаанд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр цөөнгүй бага, дунд орлоготой орнууд гадаад өрөө төлж чадахгүй, эсвэл өрийн эрсдэл өссөн нөхцөл байдалтай тулгарсан. Ингээд байгаль орчныг хамгаалах болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах нэн тэргүүний зорилттой хэдий ч гадаад өрийн шалтгаанаар төсвийн орон зай хомс улс орнуудад өмнө нь ашиглагдаж байсан ногоон өрийн свопыг зөвлөх болсон байна. Дараагийн хэсэгт ногоон өрийн свопын New development буюу дахин анхаарлын төвд орсон талаар авч үзнэ.

III. New development: Ковид-19 ба ногоон өрийн своп

3.1. Уур амьсгалын өөрчлөлт, Ковид-19 цар тахал ба өрийн хямрал

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөний эрсдэл өндөртэй улс орнуудын эдийн засаг уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмтгий салбаруудаас ихээхэн хамааралтай, төсвийн эрсдэлтэй харилцан хамааралтай байна (Зураг 3). Тодруулбал, ОУВС-ийн судлаачид бага, дунд орлоготой орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн түвшнээр медианаас дээш хэсгийг харахад ихэнх орнууд давхар төсвийн өндөр эрсдэлтэй байгааг тодорхойлсон (Chamon, Klok, Thakoor, & Zettelmeyer, 2022). Энэ хамаарал дээр хоёр талт шалтгаан байж болохыг хөгжиж буй орнуудын явж ирсэн түүх, баримт харуулна. Нэг талаар уур амьсгалын өөрчлөлт тухайн улсын үйлдвэрлэлийн боломж, татварын суурьд сөрөг нөлөөлөх, төсвийн зардал дагуулах (байгалийн гамшгийн дараах сэргээн босголтыг багтаах), гадаадаас санхүүжилтийн эх үүсвэр татах илүү өртөгтэй болох замаар өрийн эмзэг байдлыг хүндрүүлнэ. Нөгөө талаас өрийн асуудал нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад хөрөнгө оруулалт хийх төсвийн орон зайг бууруулж, нөлөөллийг хурцатгах юм.

Зураг 3. Төсвийн эрсдэл ба уур амьсгалын өөрчлөлт дахь эмзэг байдал



Тайлбар: Chamon нар эдгээр үзүүлэлтийг 128 бага, дунд орлоготой улс орнуудын хувьд гаргасан. Уур амьсгалын эрсдэлийг ОУВС-ийн уур амьсгалтай холбоотой гаргадаг индекс, төсвийн эрсдэлийг машин сургалтын загвар ашиглан үнэлгээ хийж гаргасан байна. Судлаачид мөн уур амьсгалын эрсдэлийн түвшнээр медианаас дээш байгаа 59 улсыг төсвийн эрсдэлийг дотор нь бага, дунд, өндөр гэж ангилахад өндөр эрсдэлтэй 34, дунд эрсдэлтэй 20, бага эрсдэлтэй 5 улс байгааг тодорхойлжээ.

Эх сурвалж: Chamon, Klok, Thakoor, & Zettelmeyer (2022)

Ковид-19 цар тахал улс орнуудын засгийн газрыг иргэдийн амьжиргаа, эрүүл мэндийг эн тэргүүнд хамгаалахад хүргэж, улмаар эдийн засгийн үйл ажиллагаа хумих үндэс болсон. Энэ сонголт төсвийн болон урсгал тооцооны алдагдлыг нэмэгдүүлж, хөгжиж буй орнуудын өрийн нөхцөл байдлыг эрсдэлтэй түвшинд хүргэсэн. Гэтэл хөгжиж буй орнуудын гадаад өр ковид-19 цар тахал болохоос өмнө хэдий нь дээд түвшиндээ хүрч 2019 оны эцсийн байдлаар 8 их наяд ам.доллар болж, өрийн түвшин ДНБ-д эзлэх хувиар 2010 онд 110% байснаас 170% болж нэмэгдсэн байв. Өрийн түвшин ингэж өсөхөд хэд хэдэн хүчин зүйлс нөлөө үзүүлсний нэг нь 2007-2009 оны санхүүгийн хямралын дараах хүүгийн түвшин буурч, хувийн секторын зээл хурдтай өссөн явдал юм. Түүнчлэн хөгжиж буй орнуудын гадаад өр дахь Парисын клубын орнуудын эзлэх хувь буурсан хэдий ч Хятадын эзлэх хувь орыг нь эзлэн үлэмж өссөн. Хятадын гадаад дахь зээлдүүлгийн талаар яг нарийн тоо байхгүй ч хөгжиж буй орнуудын хамгийн том албан ёсны зээлдүүлэгч (official lender) болсон байна.

Хөгжиж буй орнуудыг цар тахалтай тэмцэх, эдийн засгийн хүндрэлийг давахад нь төсвийн орон зай гаргаж өгөх, өрийн дарамтанд орохоос сэргийлэх зорилготой хөтөлбөр, санаачлагыг олон улсын байгууллага, дэлхийн тэргүүлэгч орнууд гаргасан. Тухайлбал, 2020 оны 4 сарын 5-нд Их 20-н удирдагч нар Debt Service Suspension Initiative (DSSI) буюу өрийн үйлчилгээний төлбөрийг хойшлуулах санаачлагыг зарлаж, 77 буурай орны өрийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг хойшлуулсан. Цөөнгүй хэдэн улс DSSI хөтөлбөрт хамрагдаж, өрийн төлбөрөө хойшлуулснаар 2019 оны ДНБ-д эзлэх хувиар мэдэгдэхүйц санхүүгийн эх үүсвэр гаргах боломжийг олгосон тооцоо хийгджээ. Тухайлбал, Бутан ДНБ-ий 8.4%, Ангол 3.1%, Мозамбик 2%, Тонго 1.4%, Лаос 1.4% хэмжээний санхүүжилтийг хадгалж чаджээ. Хятад улсын хувьд хөгжиж буй орнуудад олгосон зээлийн мэдээлэл болон өр төлөлтийг хойшлуулах талаарх мэдээлэл тодорхой бус хэдий ч Их 20-н хурал дээр бусад орнуудын хамт DSSI-т амлалт өгсөн. 2021 оны 12-р сараар DSSI-ийн үйлчлэх хугацаа дуусахад 2022 оноос түр зуур өрийн үйлчилгээний төлбөрөө хойшлуулж байсан орнууд үргэлжлүүлэн зээлээ төлөх дарамттай тулгарна. Дэлхийн банк, Бостоны Их сургуулийн судалгааны төв зэрэг байгууллагаас гаргасан зарим статистик, тооцоог харвал 2020 оны байдлаар DSSI-т өрийн үйлчилгээний төлбөрөө хойшлуулах хүсэлт гаргасан Тонго (55%), Лаос (52%) тэргүүтэй 17 улсын цор ганц хамгийн том зээлдэгч улс нь Хятад байсан.

Уур амьсгалын өөрчлөлтийн дам нөлөө болон зээлийн хязгаарлалтаас үүдэлтэй дутуу хөрөнгө оруулалтын асуудлыг хөнгөлөлттэй хүүгийн нөхцөлтэй зээл болон үр дүнд тулгуурласан зээлээр шийдэж болно. Эхнийх нь хувийн зээлдүүлэгч эрсдэлээ тооцож өндөр хүүгээр зээлдүүлэх байсан зээлийг засгийн газар, олон улсын байгууллага хүүгийн хөнгөлөлт үзүүлж зээлдүүлэх замаар зардлыг бууруулах юм. Харин үр дүнд тулгуурласан зээл нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон байгаль орчныг хамгаалах төсөл болон гүйцэтгэлийн гол үзүүлэлттэй уялдуулж зээлийг олгох юм. Гэсэн хэдий ч олон хөгжиж буй орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөрөнгө оруулалтыг хэдий хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжүүлэх боломж байгаа ч төсвийн орон зай дутмаг байдаг. Энэ бол өрийн түвшин тогтвортой түвшнээс давсан орнуудын хувьд илт байна. Түүнчлэн өрийн хэмжээ нь тогтвортой түвшинд байгаа хөгжиж буй орнууд ч үр ашигтай дасан зохицох хөрөнгө оруулалт хийхэд төсвийн орон зайгаар дутаж болно (Aligishiev, Bellon, & Massetti, 2022). Учир нь, энэ нөхцөлд ногоон зээл, ногоон бонд зэрэг байгаль орчны стандарт санхүүжилтийн хэрэгсэл өрийг нэмж тогтвортой түвшнээс давуулж өрийн дарамтыг нэмнэ. Үүний оронд өрийн бүтцийг бүхлээр өөрчлөх эсвэл хуучин өрийн түвшинг нэмэлгүй ногоон өрийн свопоор сольж, төсвөөс байгаль орчны хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх орон гаргах оновчтой байна.

3.2. Ногоон өрийн свопын хэрэгцээ өссөн нь

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, дасан зохицох, байгаль орчныг хамгаалахад хөрөнгө оруулалт хийхэд тулгарч байгаа гол хязгаарлалт нь төсвийн орон зай байгаа үед тохирох

санхүүгийн хэрэгсэл нь ногоон өрийн своп байна. Steele ба Patel (2020) нар энэ шалгуурын дагуу ногоон өрийн своп сонгох нэн тэргүүний шаардлагатай байгаа тухайлсан улсын үнэлгээ гаргасан. Судалгаанд 67 улсыг хамруулж, ногоон своп сонгох нэг шаардлагатай байгаа улсын эрэмбэ гаргахдаа улс бүрийн хувьд дөрвөн талбар дахь индексийн утгын харьяалагдах квартил, түүнд хуваарилсан оноо, тэдгээрийн нийлбэрээр эрэмбийн утга гаргасан ба хамгийн ихдээ 16 оноо байна. Энэ эрэмбийн нийлбэр өндөр байхын хэрээр тухайн улсын хувьд ногоон өрийн свопын хэрэгцээ өндөр байхыг илтгэнэ. Хүснэгт 1 уг судалгаанаас гарсан гол үр дүн болох ногоон өрийн своп нэн тэргүүн сонгох, хэрэгжүүлэх шаардлагатай 14 улсын харуулна. Уг судалгааны ажилд Монгол улс багтсан тул үнэлгээний үр дүн энэ өндөр оноотой улсуудад багтаагүй ч эрэмбийн утгыг давхар харуулсан. Хүснэгтээс харвал Кабо-Верде, Вьетнам улсууд тус бүр хамгийн өндөр 15 эрэмбийн оноотой тэр хэрээр ногоон өрийн свопыг сонгож, хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Эдгээр улсын дараагаар Гондурас, Кени, Никарагуа, Шинэ Гвиней улсууд 14 оноотой байна. Монгол улсын хувьд эрэмбийн утга 11 оноо авч, биологийн олон янз байдлын хорогдол, өрийн байдал, зээл төлөх чадвараар эрсдэл өндөртэй гэж үнэлэгдсэн байна.

Хүснэгт 1. Бага, дунд орлоготой орнуудыг байгаль орчны хамгаалахад ногоон өрийн своп ашиглах шаардлагын эрэмбэ

Эрэмбийн утгын нийлбэр ^а	Улс	Уул амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдал ^б	Биологийн олон янз байдлын хорогдол ^в	Өртэй байдал ^г	Зээл төлөх чадвар ^д
15	Кабо-Верде	18.02	94.12	89.30	3.77
15	Вьетнам	10.31	470.06	46.70	3.39
14	Гондурас	11.39	281.81	43.73	3.45
14	Кени	10.30	343.82	36.14	3.69
14	Никарагуа	13.78	127.34	90.70	3.51
14	Шинэ Гвиней	22.18	991.61	78.39	3.00
13	Камбодж	15.13	135.65	58.24	3.38
13	Киргиз	7.28	42.63	102.98	3.58
13	Мадагаскар	10.49	1139.44	31.76	3.28
13	Мозанбик	9.50	280.15	107.57	3.21
13	Сенегал	9.82	39.86	52.37	3.72

13	Шри Ланк	7.50	306.73	60.85	3.38
13	Уганда	8.71	107.96	46.34	3.68
13	Вануату	56.71	81.39	45.95	3.38
11	Монгол	3.00	162.22	253.87	3.38

Тайлбар: ^а-Дөрвөн үзүүлэлт бүр 4 бүлэг буюу квартил хэсэгт хувааж, улмаар тухайн улсын үзүүлэлт хамгийн бага ба квартил 1 түвшний хооронд байвал 1 оноо, квартил 1-ээс квартил 2 хооронд байвал 2 оноо, квартил 2-аас квартил 3 хооронд байвал 3 оноо, квартил 3-аас их, хамгийн их түвшнээс бага бол 4 оноог өгч, улмаар дөрвөн үзүүлэлтийн онооны нийлбэрээр эрэмбийн утга гаргасан. ^б-Уул амьсгалын өөрчлөлтөд эмзэг, эрсдэлтэй байдлыг судалгаанд хамрагдсан орнуудын 2019 оны тоо мэдээлэл дээр World Risk Index for climate and disaster risk индекс тооцон гаргасан ба утга өсөхийн хэрээр нөлөө, эрсдэл ихтэй улс болохыг харуулна. ^в- Биологийн олон янз байдлын хорогдлыг 2008 оны тоо мэдээлэл дээр Global Environment Facility Benefit Index for Biodiversity индекс тооцон гаргасан ба мөн утга өндөр байхын хэрээр биологийн төрөл зүйл цөөрсөн, хохиролтой байгааг харуулна. ^г- Өртэй байдлыг Дэлхийн банкны гаргадаг улсын гадаад өрийн үндэсний нийт орлогод эзлэх хувийн үзүүлэлтээр авсан ба 2018 оны оны байдлаар статистик харуулсан. ^д- Зээл төлөх чадварыг 2019 оны тоо мэдээлэл дээр Дэлхийн банкны Resource Allocation Index индекс тооцон гаргасан ба утга өндөр байхын хэрээр зээлээ төлөх чадвартай байна.

Эх сурвалж: Steele & Patel (2020)

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хөгжиж буй орнуудын төсвийн алдагдал, гадаад өрийн хэмжээ үлэмж өсч, тэр хэрээр ногоон өрийн свопын давуу байдал нэмэгдэж байна. 2021 оны байдлаар 64 бага дунд орлоготой орны төсвийн орон зайг гадаад өрийн өнөөгийн өртгийн ДНБ-д эзэх хувийг ОУВС ба Дэлхийн банкны тодорхойлсон Debt sustainable framework-ийн өрийн эрсдэлийн босго түвшинтэй харьцуулж тооцсон судалгааны үр дүнгээс 43 улс ДНБ-ий 20 хувиас бага төсвийн орон зайтай, 33 улсынх 10 хувиас бага, 28 улсынх сөрөг төсвийн орон зайтай байгаа үнэлгээ хийсэн (Chamon, Klok, Thakoor, & Zettelmeyer, 2022). Түүнчлэн энэ судалгааны ажил бага орлоготой 29 улсын дөнгөж 7 улс нь Парисын хэлэлцээг хэрэгжүүлэх үндэсний хувь нэмрийн амлалтаа биелүүлэх санхүүгийн орон зайтай байгааг тооцсон байдаг. Нөгөө талаас саяхан хүртэл ногоон өрийн свопыг бага хэмжээгээр өрийг бууруулдаг, өндөр хэлцлийн зардалтай тул давуу тал бага гэж үздэг байлаа. 2015 онд Сейшел 21.6 сая доллар, 2021 онд Белиз 553.0 сая ам.доллар, 2023 онд Эквадор 1.6 тэрбум ам.долларыг ногоон өрийн свопоор сольж, тэр хэмжээгээр хэлцлийн зардлыг бууруулж, энэ арга хэрэгслийн ач холбогдол өсч байна.

Судлаачид ногоон свопын үр өгөөжийг зээлдэгч буюу өртэй улсын хувьд авч үзэхээс гадна зээлдүүлэгч улс, ялангуяа Парисын клубын гишүүн биш орнуудын хувьд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Өртэй улсын хүртэх өгөөж:

- Төсвийн орон зай нэмэгдэх: Гадаад өр ихтэй улс орнуудын хувьд өрийн өндөр түвшнээс шалтгаалан гадаадаас дахин зээл авах, бонд гаргах боломж хязгаарлагдмал тул үлдэж байгаа боломжит нэг арга зам нь энэ хуучин өрийг свопоор хувиргаж, гадаад өрийн үйлчилгээний төлбөрийг бууруулан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг гаргана.

- Макро эдийн засгийн тогтвортой байдал хангагдах: Ногоон өрийн своп тухайн улсын гадаад өрийн хэмжээг бууруулахад дэмжлэг болдог. Энэ нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх ба улмаар зээлжих зэрэглэлийг ахиулах, олон улсын санхүүгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг бүрдүүлнэ.
- Шинэ тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр татах боломж нээгдэх: Ногоон өрийн свопын хэлцэл амжилттай хийснээр өрөө хувиргаж байгаа улсын засгийн газар давхар дэвшилтэт өрийн хэрэгсэл ашиглах туршлага, чадварыг хуримтлуулдаг. Сейшел улсын туршлагаас харахад 2015 онд байгаль орчны өрийн своп хийж, улмаар тогтвортой санхүүжилтийн дараагийн эх үүсвэр болох blue бонд амжилттай гаргасан.

БНХАУ тэргүүтэй Парисын клубын гишүүн бус орнууд: Хөгжиж буй орнуудад олгосон албан зээлийн хамгийн том зээлдүүлэгч нь Хятад улс гэдгийг өмнө дурдсан. Хятадын хувьд ногоон өрийн свопыг хэрэгжүүлэх нь давхар хэд хэдэн үр өгөөжтэй. Тухайлбал, БНХАУ ногоон өрийн своп санаачлан хэрэгжүүлснээр зээлдэгч улстай эдийн засаг, улс төр, хүн хоорондын харилцааг нэмэгдүүлэх боломжийг олохын зэрэгцээ Парисын хэлэлцээрийн дагуу уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, дасан зохицох олон улсын нийтлэг зорилтыг хангахад их гүрний хүлээх үүргээ биелүүлсэн нэр хүндийг олж авна. Түүнчлэн Хятад улс Бүс ба Зам санаачлагын хүрээнд хөгжиж буй орнуудад их хэмжээний зээл өгсөн байдаг. Хятадад их өртэй улс зээлээ төлж чадахгүй default болох эрсдэлээс зайлсхийж чадсанаар тус улсын засгийн газар, банкны зээл эрсдэлгүй болох, гадаад дахь хөрөнгө оруулалтын аюулгүй байдал нэмэгдэнэ. Мөн өрийг ногоон өрийн свопоор сольсноор тус улсын дэвшүүлсэн “Ногоон Бүс ба Зам”-д шууд хувь нэмэр оруулна.

Нөгөө талаас судлаачид ногоон өрийн свопыг нэмэгдүүлэх дараах арга замыг зөвлөдөг. Үүнд:

- *Улсын хэмжээний KPI тогтолцоо бий болгох:* Steele ба Patel (2021) нарыг судлаачид ногоон өрийн свопын хэмжээг нэмэгдүүлэх нэг арга зам бол улс орны хэмжээнд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гүйцэтгэлийн үнэлгээний KPI-Key Performance Indicators тогтолцоотой түүнийг холбохыг зөвлөдөг. KPI тогтолцоо нь өрийн свопыг дагасан байгаль орчны амлалт, биелэлтийн хяналт үнэлгээний зардлыг бууруулах давуу талтай гэж тайлбарладаг. KPI тогтолцоо нь улс орны хэмжээний нэн тэргүүнд хүрэх байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн үр дүнг тусгахаас гадна эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах зорилтууд ч багтаахыг зөвлөдөг[§].
- *Олон улсын өрийг хөнгөлөх, байгаль орчны дэмжих бүтэц, байгууллагад нэгдэх.* Энэ бүтэцэд нэгдсэнээр ногоон өрийн свопыг бага хэлцлийн зардлаар тохиролцох боломжийг олгодог. Жишээлбэл, Их 20-н орнуудын DSSI санаачилга анхны MoU-ыг Их 20-н орнууд ба өртэй улс орнуудын хооронд бүх орнууд нийтлэг нөхцөлөөр хэлэлцээг эхлүүлэхээр хийсэн. Энэ бүтэц нь зээлдэгч улс орнуудыг бас ижил нөхцөлөөр хувийн зээлдүүлэгчийн өмнө нь амлалт өгүүлдэг. Иймд энэ тогтолцоо нь талуудын хэлэлцээ хийх үйл явцын эхлэлийг хялбар болгох замаар хэлцлийн зардлыг бууруулж, тэгш шударга байдлыг нэмэх боломжтой.
- *Хэлцэлд оролцогч талуудыг өргөжүүлэх:* Аль болох олон зээлдүүлэгч нарыг ногоон өрийн свопын энэ хэлэлцээрт татан оролцуулах, ялангуяа хувийн хөрөнгө оруулагч нарт хөшүүрэг өгөх хэрэгтэй. Байгаль орчин, сайн засаглалын амлалт өгсөн хөрөнгө оруулагч нар гарч ирэх болсон. Тэдгээрийн хөрөнгө оруулалтын багцдаа уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа дэмжсэн өрийн хэрэгсэл багтаасан үүрэг амлалтыг ашиглах, өрийн

[§] KPI тогтолцоо давхар улс төрийн амлалт, зорилтод үр дүнд хүрэх үйл ажиллагаа, зардал, ахиц дэвшлийг үнэлэх механизм агуулна. Steele, Patel & Beauchamp (2021) нарын “Key Performance Indicators for climate and nature outcomes for debt management: Methodology with examples from West Africa” судалгааны ажлаас өрийн своп дээр KPI тогтолцоо нэвтрүүлэх үе шат, сорилт, зарим жишээг дэлгэрүүлж үзэх боломжтой.

свопоо санал болгох боломж гарч байна. 2023 онд Эквадор 1,6 тэрбум ам.долларыг ногоон өрийн свопоор сольсон нь нэг талаар энэ нөлөөний үр дүн юм.

- *Төслөөс хөтөлбөрт суурилах:* Өмнө явж ирсэн төсөлд суурилсан свопын хэмжээг харилцан хамааралтай төслүүдийг нэгтгэж, бодлогын шинэчлэлтэй холбох замаар нэмэгдүүлэх боломжтой. Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, дасан зохицох бодлогын нэгдсэн төлөвлөгөөнд нүүрсний цахилгаан станцаас татгалзах, сэргээгдэх эрч хүчний үйлдвэр барих, дэд бүтэц, хөдөө аж ахуй системийг бий болгох төслүүдийг багцалж болно. Улмаар төслүүдийн багцаа бодлогын шинэчлэлтэй хослуулснаар нийгэм эдийн засгийн бүтцийн шилжилт хийхэд түлхэц болно.
- *Олон улсын санхүүгийн байгууллагаас баталгаа гаргуулах:* 2022 онд ОУВС Resilience and Sustainability Trust-ийг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлогын шинэчлэлийг дэмжих бүтцээр баталсан. ОУВС болон бусад олон улсын санхүүгийн байгууллага тухайн улсын Парисын хэлэлцээр дэх үндэсний хувь нэмрийг хангахад шаардлагатай байгаа бодлогын шинэчлэлийг хийхэд амлалтыг хангах баталгааны үйлчилгээ үзүүлдэг. Энэ нь амлалтын бэрхшээлийг олон улсын санхүүгийн байгууллагатай тохиролцоо хийх, амлалт гаргуулах замаар шийдэх, өрийн свопын хэмжээг нэмэгдүүлэх боломж олгох юм. Үүний саяхны жишээ нь Белиз 2021 онд 553,0 сая ам.долларын бондоо ногоон өрийн своп руу хямдруулж хувиргахад АНУ-н Олон Улсын Хөгжлийн Корпораци зээлийн эргэн төлөлтөд улс төрийн эрсдэлийн баталгаа гаргасан тохиолдол юм.


3.3. Белиз болон Эквадор улсын кейс судалгаа

Бид 2021, 2023 онуудад ногоон өрийн свопын хэлцлийг амжилттай байгуулсан Белиз, Эквадор улсуудын кейсээр уг өрийн хэрэгсэл Ковид-19 цар тахлын дараах хөгжиж улсын орнуудын өмнө тулгарсан гадаад өрийн дарамтыг бууруулах, давхар байгаль орчныг хамгаалах санхүүжилтийг шийдэх боломж олгохыг харууллаа.

Белиз

Белиз улс нь Карибын орнуудын нэг ба хөдөө аж ахуйн, аялал жуулчлал, үйлчилгээний салбараас голчлон хамаардаг эдийн засагтай. Ковид-19 цар тахлаас шалтгаалан аялал жуулчлалын салбарын орлого буурснаар Белизын эдийн засаг 2020 онд 16.7 хувиар агшиж өрийн хэмжээ ДНБ-ий 133%-д хүрчээ. Ийнхүү эдийн засгийн байдал хүндэрснээс шалтгаалан тус улс гадаад өрөө зах зээлийн хүүгээр дахин санхүүжүүлэхэд өртөг өндөртэй болж, энэ нь цаашид тус улсын эдийн засагт хүнд дарамт болохоор байв. Тус улсын засгийн газар 2020 оны сүүлээс эхлэн TNC байгууллагатай хамтран ажиллаж гадаад өрийн нөхцөлөө сайжруулах, байгаль орчныг хамгаалахад шаардлагатай байгаа санхүүжилт босгох зэрэг асуудлаар хамтран ажиллажээ. Улмаар 2021 онд Белиз улс TNC байгууллагатай ногоон өрийн своп хэлцэл байгуулсан. Хэлцлийн хүрээнд Белиз улс 553 сая ам.долларын дүн бүхий “Супербонд” нэртэй евробондыг хямдруулан худалдаж авсан. TNC талаас Белизэд зориулан 364 сая ам.долларын “цэнхэр” бонд гаргасан бөгөөд уг бондын эх үүсвэрийг Белизэд зээлж, гадаад өрийг нь хоёрдогч зах зээлээс худалдан авчээ (Зураг 4-т Белиз улсын өрийн своп хэлцлийн схемийг харуулав).

Зураг 4. Белиз улсын өрийн своп хэлцлийн схем




Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Энэхүү бонд нь 19 жилийн хугацаатай, эхний 10 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй байв. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Санхүүгийн Корпораци уг бондын зээлийн эрсдэлийг даатгасан. Тус улсын хувьд олон улсад нэр хүндтэй банкаар андеррайтер хийлгэн, зээлийн эрсдэлийн даатгал, батлан даалтыг хэлцэлдээ тусгаж чадсан нь бондын эрсдэлийг бууруулж улмаар купон багатай байх гол үүргийг гүйцэтгэжээ. Ийнхүү өрийн нөхцөлөө сайжруулсны хариуд Белиз улс 2041 он хүртэл далай тэнгисийг хамгаалах үйл ажиллагаанд жил бүр 4 сая ам.доллар зарцуулахаар болсон. Үүний үр дүнд далай тэнгисийн хамгаалалттай газрынхаа хэмжээг хоёр дахин тэлж, нийт усан хилийнхээ 30 хувийг 2026 он гэхэд хамгаалалттай бүс болгохоор болжээ. Түүнчлэн тусгай хамгаалалттай бүсийн санхүүжилтийг 2040 оноос хойш 23.5 сая ам.долларын сан бүхий өв сангаас гаргана. Хэлцэл байгуулагдсанаар Белиз улс 553 сая ам.долларын хэмжээтэй “Супербонд”-ыг 364 сая ам.долларын “цэнхэр зээл”-ээр сольж, өрийн хэмжээ 189 сая ам.доллаар буурсан нь тухайн үеийн ДНБ-ий 12 хувьтай тэнцэхээр байжээ. Мөн өрийн нөхцөл өөрчлөгдсөнөөр зээлийн хугацаа 6.5 жилээр урт болж, өрийн тогтвортой байдлын үзүүлэлт сайжирсан нь зээлжих зэрэглэл тогтоогч S&P агентлагаас Белиз улсын зээлжих зэрэглэлийг хэсэгчлэн дампуурлаа зарласан ангиллаас В- болгон төлөвийг шат ахиулан үнэлсэн.

Эквадор

Эквадор улс нь Өмнөд Америкийн баруун эрэгт оршдог Амазоны ширэнгэн ой, Галапагосын арлууд зэрэг байгалийн өвөрмөц газрууд бүхий улс юм. Тус улсын эдийн засаг нь газрын тос, банана, сам хорхой, алт зэрэг түүхий эдийн экспортоос өндөр хамаардаг. Ковид-19 цар тахлын үед газрын тосны үнэ огцом унасан нь Эквадор улсын эдийн засагт хүндээр тусч, 2020 онд ДНБ 7.8 хувиар буурчээ. Улмаар 2020 оны 4-р сард тус улс хэсэгчлэн дампуурал зарласан. Ийнхүү эдийн засгийн хүндрэлд орж, дампуурал зарласнаар гадаад зээлийн өртөг өндөр болж, цаашид өрөө дахин санхүүжүүлэхэд хүндрэлтэй болжээ. Эквадорын засгийн газар Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт болон Дентон хуулийн фирм байгууллагуудаас зөвлөгөө авч Кредит Свисс банкаар дамжуулан 2023 оны 5-р сард 1,6 тэрбум ам.долларын дүнтэй гадаад зах зээлд гаргасан бондоо

Зураг 5. Эквадор улсын өрийн своп хэлцлийн схем



Уг хэлцэлд Кредит Свисс банк зуучлагчаар ажилласан бол АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Санхүүгийн Корпораци 656 сая ам.долларын дүн бүхий зээлд улс төрийн эрсдэлийн даатгал, Интер-Америкийн Хөгжлийн Банк 85 сая ам.долларын баталгаа гаргасан байна. Уг хэлцлээр дээр дурдсан хувийн хэвшилээс идэвх санаачилга өндөртэй оролцсон тул энэ нь өмнөх бусад өрийн своп хэлцүүдийг бодвол зардал болоод хугацааны хувьд мэдэгдэхүйц бага буюу 1.5 жилийн хугацаа зарцуулжээ. Түүнчлэн Эквадор улсын гаргасан Галапагос бондын купон 5.6%, хугацаа 18 жилийн хугацаатай байв. Эквадорын засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан ам.долларын бусад бондын өгөөж 2023 оны 5 дугаар сард 17-26% байжээ.

IV. Монгол улсын хувьд ногоон өрийн своп хэрэглэх боломжийн судалгаа

4.1. Монгол улсын уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бодлого, арга хэмжээний санхүүжилтийн өнөөгийн байдал, хэрэгцээ

Монгол улс бодлогын баримт бичгүүд дундаа уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх талаар тусгаж байсан боловч одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй томоохон бодлогынх баримт бичгүүд нь 2010 оны УИХ-ын 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5-д “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”-ыг хэрхэн хангах талаар тусгасан бөгөөд үүнд уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаврыг бууруулах тухай дэд бүлэг болгон оруулжээ. Харин үүний дараа 2020 онд УИХ-ын 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Энэхүү баримт бичгийн 6 дугаар бүлэгт ногоон хөгжлийн урт хугацааны бодлогыг тодорхойлон гаргажээ. Үүнээс гадна Монгол улс Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхийн тулд улс бүрийн авах арга хэмжээг тодорхойлсон баримт бичиг болох Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт (ҮТХНЗ)-ыг 2019 онд Засгийн газрын 407 дугаар тогтоолоор баталсан байдаг. Энэхүү баримт бичиг нь өмнөх баримт бичгүүдээс ялгаатай нь хүлэмжийн хийг бууруулахад ямар арга хэмжээ авах, үүний үр дүнд хэдий хэмжээний нүүрс хүчлийн хийн ялгарлыг бууруулахыг тусгасан бөгөөд уг арга хэмжээнд хэдий хэмжээний санхүүжилт шаардагдахыг мөн тооцоолсноороо онцлог юм. Уг зорилтод зааснаар Монгол улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтаа 16.9 сая тонн CO₂-экв-аар буюу суурь түвшинтэйгээ харьцуулахад 22.7 хувиар бууруулах зорилт тавиад байна (Хүснэгт 2). Монгол улсад 2023 оны эцсийн байдлаар олгосон ногоон зээлийн үлдэгдэл 800.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа нь Хүснэгт 2-т дурдсан санхүүжилтийн хэрэгцээ шаардлагын дөнгөж 2.6%-ийг эзэлж байна.

Хүснэгт 2. ҮТХНЗ-ын дагуу 2030 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт

Үйл ажиллагаа	Арга хэмжээ	CO ₂ ялгарлыг бууруулах (сая тонн CO ₂ -экв)	Шаардлагатай санхүүжилт (тэрбум төгрөгөөр)
<i>А. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах</i>			
Эрчим хүчний үйлдвэрлэл	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх	2.97	2,800
	Эрчим хүч үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх	5.37	1,400
	Өндөр технологи бүхий цэвэр эрчим хүчний томоохон эх үүсвэр шинээр барих	-	3,080
Эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх	Аж үйлдвэр	1.05	1,120
	Барилга	0.83	840
	Тээвэр	1.05	980
Аж үйлдвэрийн процесс ба бүтээгдэхүүний хэрэглээ		0.23	1,680
Хөдөө аж ахуй		5.28	2,520


Хог хаягдал	0.11	1,400
Ой	-	840
ХХЯ-ыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээний нийт зардал	16.89	16,660
<i>Б. Дасан зохицох арга хэмжээ</i>		
Эрдэм шинжилгээ, судалгааны ажил		1,200
Мал аж ахуй, бэлчээр		160
Газар тариалан		372
Усны нөөц		5,308
Биологийн олон янз байдал		124
Ойн аж ахуй		1,700
Гамшгийн эрсдэлийн менежмент (цаг агаар, үер усны гамшгаас эртнээс сэрэмжлүүлэх системийг оролцуулан)		4,070
Нийгмийн эрүүл мэнд		360
Иргэдийн амьжиргаа, нийгмийн хамгаалал		360
Дасан зохицох арга хэмжээний нийт зардал		13,654
НИЙТ ДҮН		30,314

Эх сурвалж: БОАЖЯ, 2020

Дэлхийн бусад улс орнууд ногоон шилжилт хийхдээ төр засгаас их хэмжээний санхүүжилт гаргах, олон улсын зах зээлээс ногоон зээл, бонд босгох замаар санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлж байна. Гэтэл Монгол улсын гадаад өрийн түвшин 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 33.8 тэрбум ам.доллар буюу ДНБ-ээс 2 дахин өндөр түвшинд хүрч, засгийн газрын өрийн түвшинг бусад улс орнуудтай харьцуулахад хөгжлийн түвшин ижил улс орнуудаасаа өндөр байна (Зураг 5).

ОУВС-гаас 2023 онд хийсэн өрийн тогтвортой байдлын шинжилгээний үр дүнгээр Монгол улсын өрийн түвшин өндөр эрсдэлтэй хэмжээнд хүрсэн гэж дүгнэсэн явдал үүний нэг нотолгоо. Үүнээс үзэхэд өмнөх бүлэгт дурдаж байсан дэлхийн бусад улс орнуудад үүсээд буй уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд шаардагдах санхүүжилт хязгаарлагдмал байдал Монгол улс харьцангуй өндөр ажиглагдаж байна.

Зураг 6. Засгийн газрын гадаад өр ба ДНБ-ий харьцаа, 2020 оны байдлаар




Эх сурвалж: ОУВС (2023)

4.2. Монгол улсын хувьд ногоон өрийн своп хэрэглэх боломжийн судалгаа

Өмнөх бүлэгт дурдсанчлан Монгол улсын хувьд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх ногоон санхүүжилтийн эх үүсвэр туйлын хангалтгүй, шинээр эх үүсвэр олон улсын зах зээлээс босгоход хүндрэлтэй нөхцөлд ашиглаж болох нэг шийдэл нь ногоон өрийн своп хэлцэл юм. Өрийн своп хэлцэл байгуулах боломж нь нэг талаас Монгол улсын гадаад өрөөс, нөгөө талаас өнөөг хүртэл байгуулж байсан өрийн своп хэлцлийн ерөнхий зарчим нөхцөлөөс хамааран тодорхойлогдоно.

Монгол улсын хувьд 2023 оны эцсийн байдлаар 34.6 тэрбум ам.доллар байгаагийн 7.9 тэрбум ам.долларыг Засгийн газрын, 1.8 тэрбум ам.долларыг Төв банкны гадаад өр тус тус бүрдүүлж байна. Ногоон өрийн своп хэлцлийг зөвхөн төрийн (public) гадаад өр дээр хийдэг тул энэ бүлэгт Засгийн газар, Төв банкны гадаад өрийг хэрэгслийн төрөл, зээлдүүлэгчээр нарийвчлан авч үзлээ. Төв банкны гадаад өрийн дийлэнхийг буюу 1.5 тэрбум ам.долларыг Монголбанкны Хятадын Ардын Банктай байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн хүрээнд авсан юанийн өглөг бүрдүүлж байна. Харин Засгийн газрын гадаад өрийн 5.9 тэрбум ам.долларыг гадаадын зээл, 2.0 тэрбум ам.долларыг гадаад зах зээлд гаргасан бонд бүрдүүлж байна. Засгийн газрын гадаад зээлийг зээлдэгчдээр задалж үзвэл Парисын клубт харьяалагдах улс орнуудаас авсан зээл 1.5 тэрбум ам.доллар, Парисын клубт хамаарахгүй зээлдүүлэгчдээс авсан зээл 4.4 тэрбум ам.доллар байна (Зураг 7).

Зураг 7. Монгол улсын Засгийн газарт зээл олгосон гадны зээлдүүлэгчид



Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Парисын клубт харьяалагддаггүй зээлдүүлэгчдээс авсан зээлийн 3.1 тэрбум ам.долларыг олон улсын байгууллагаас, 1.0 тэрбум ам.долларыг БНХАУ-аас, 229 сая ам.долларыг Энэтхэг улсаас 56 сая ам.долларыг бусад зээлдүүлэгчдээс авчээ (Монголбанк, 2024).


Гадаад өрийн бүтцээс үзэхэд дараах гурван хувилбараар ногоон өрийн своп байгуулах боломж харагдаж байна. Үүнд:

- i. Парисын клубын улс орнуудтай олон талт өрийн своп хэлцэл байгуулах,
- ii. БНХАУ-тай хоёрт талт өрийн своп хэлцэл байгуулах,
- iii. Ногоон өрийн своп хэлцэл байгуулах чиглэлээр мэргэшсэн TNC зэрэг байгууллагаар дамжуулан гадаад өрийг хоёрдогч зах зээлээс хямдруулан худалдан авах.

Өнгөрсөн хугацаанд байгуулагдсан өрийн своп хэлцлийн жишээг хэлцлийн төрөл, хэлцэл байгуулсан цаг хугацаа гэх мэт хүчин зүйлсээр ангилан дээр дурдсан 3 төрлийн өрийн своп хэлцэл байгуулах тохиодол тус бүрд бий болгох ногоон санхүүжилтийн хэмжээг кейс судалгаанд үндэслэн доорх байдлаар тодорхойллоо.

Ногоон өрийн своп хэлцэл байгуулагдаж эхэлсэн цагаас өнөөг хүртэл хугацаанд байгуулагдсан 146 хэлцлийн мэдээллийг энэхүү судалгаанд ашиглав (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү). Нийт байгуулсан 146 өрийн своп хэлцлийн дүн 5.3 тэрбум ам.доллартай тэнцэж байгаа бөгөөд зээлдүүлэгчдийн хувьд Парисын клубын улс орнууд 94 удаагийн хэлцлээр нийт 3.0 тэрбум ам.долларын үнийн дүн бүхий хэлцлийг байгуулжээ.

Зураг 8. Ногоон өрийн своп хэлцэл



Эх сурвалж: African Natural Resources Management and Investment Centre (2022)

Ногоон өрийн своп хэлцэл байгуулсан улс орнуудын кейсд үндэслэн Монгол улс ногоон өрийн своп хэлцэл байгуулах тохиолдолд босгох санхүүжилтийн дүнг тэгшитгэл 1-д үзүүлсний дагуу тооцоолов.

$$gf = \bar{w} * D \quad (1)$$

Тайлбар: gf нь ногоон өрийн своп хэлцлээр босгох санхүүжилтийн дүн

$\bar{w}$ нь бусад улс орнуудын ногоон санхүүжилт босгосон дундаж хувь

D нь Монгол улс өрийн своп хэлцэлд ашиглах гадаад өрийн хэмжээ

$$\bar{w} = \sum_{i=1}^k EF_i / \sum_{i=1}^k DS_i \quad (2)$$

Тайлбар: EF_i нь i хэлцлээр босгосон ногоон санхүүжилтийн дүн

DS_i нь i хэлцэлд ашигласан гадаад өрийн дүн

k нь тухайн төрлийн ногоон өрийн своп хэлцэл хийсэн нийт тоо

Монгол улс ногоон өрийн своп хэлцлийг Парисын клубын улс орнуудтай байгуулах тохиолдолд $\bar{w}$ буюу бусад улс орнуудын ногоон санхүүжилт босгосон дундаж хувийг тооцоолон Хүснэгт 3-т үзүүлэв. Уг үзүүлэлтийг ашиглан Парисын клубын улс орнуудаас Монгол улсын авсан 1.5 тэрбум ам.долларын дүн бүхий гадаад зээлд ногоон өрийн своп хэлцэл байгуулсан тохиолдолд тэгшитгэл 1-д үзүүлсний дагуу тооцоолоход 0.6-1.5 тэрбум ам.доллар буюу 2.1-5.1 их наяд төгрөгийн ногоон санхүүжилтийг босгох боломжтой байна**.

** Бүх хэлцлийн дундажаар тооцвол Парисын клубын улс орнуудын хувьд $\bar{w} = 0.50$, харин тус орнуудын 2000 оноос хойш байгуулсан хэлцлийн $\bar{w} = 1.01$ байхаар тооцооллыг гүйцэтгэсэн. Ам.долларын дүнг төгрөгт хөрвүүлэхдээ Монголбанкны 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн албан ханш (1\$ = 3,376.29₮)-аар хөрвүүлэв.

№	Хамрах хугацаа	Ногоон санхүүжилтийн хувь	Үүнээс зээлдүүлэгч нь:	
			Парисын клубын гишүүн	Парисын клубын гишүүн бус
1	Нийт	0.41	0.50	0.29
2	1980-2000	0.43	0.42	0.77
3	2001-2023	0.38	1.01	0.26

Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт

Энэ нь Монгол улсын Засгийн газраас Парисын гэрээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн (Хүснэгт 2-т дурдсан) арга хэмжээний эрчим хүч үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өндөр технологи бүхий цэвэр эрчим хүчний томоохон эх үүсвэр шинээр барих гэсэн хоёр цогц үйл ажиллагааг бүхэлд нь санхүүжүүлэх эх үүсвэр болохоор байна. Уг хоёр арга хэмжээг санхүүжүүлж, хэрэгжүүлэх тохиолдолд Монгол улсын хүлэмжийн хийн ялгарал 5.4 сая тонн CO₂-экв-аар буурах юм.

Харин Парисын клубын бус улс орнуудаас авсан Монгол улсын төрийн зээлээс олон улсын байгууллагуудын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг эс тооцвол хамгийн том зээлдүүлэгч нь БНХАУ байгаа бөгөөд тус улсаас авсан гадаад өглөгийн нийт дүн 2.5 тэрбум ам.доллар байна. Хэдийгээр БНХАУ одоогоор бусад улс орнуудтай өрийн своп хэлцэл байгуулаагүй боловч цаашид өрийн своп хэлцлийн хэрэглээ нэмэгдэх хандлагатай байгаа, тус улсаас зээл авсан улс орнууд өрийн своп хэлцэл байгуулах хүсэлт эхнээсээ гаргаж байгаа, цаашилбал тус улс нь дэлхийн хүлэмжийн хийн хамгийн том ялгаруулагч улс болсон зэргийг харгалзан үзэхэд тус улс бусад зээлдэгч орнуудтай өрийн своп хэлцэл байгуулах нь дамжиггүй юм. Иймд БНХАУ-тай өрийн своп хэлцэл байгуулах бэлтгэлийг эртнээс хангахад цаашид танилцуулах мэдээлэл гол ач холбогдолтой. Өнгөрсөн хугацаанд байгуулагдсан хэлцлүүдээс зээлдүүлэгч нь Парисын клубын гишүүн бус оронтой 52 удаагийн хэлцлээр 2.4 тэрбум ам.долларын ногоон өрийн своп хэлцэл байгуулжээ. Эдгээр хэлцлүүдийн хувьд $\bar{w}$ үзүүлэлтийг тооцон Хүснэгт 3-д үзүүлэв. БНХАУ-тай байгуулах ногоон өрийн свопыг тус улсаас авсан төрийн нийт гадаад өр болох 2.5 тэрбум ам.доллараар байгуулна гэж үзэн тэгшитгэл 1-ийн дагуу тооцоолоход 0.7-1.9 тэрбум ам.доллар буюу 2.2 - 6.5 их наяд төгрөгийн ногоон санхүүжилтийг бий болгох боломжтой байна. Энэ нь Монгол улсын Засгийн газраас Парисын гэрээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн (Хүснэгт 2-т дурдсан) арга хэмжээний сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эрчим хүч үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх гэсэн хоёр үйл ажиллагааг бүхэлд нь санхүүжүүлэх эх үүсвэр болохоор байна. Уг хоёр арга хэмжээг санхүүжүүлж, хэрэгжүүлэх тохиолдолд Монгол улсын хүлэмжийн хийн ялгарал 8.4 сая тонн CO₂-экв-аар буурах юм.

Гурав дахь хувилбарын дагуу Монгол улсын засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан евро бондыг хоёрдогч зах зээлээс хямдруулан худалдан авах тохиолдолд тэгшитгэл 3-д үзүүлсэн хэмжээгээр гадаад өрийн хэмжээ буурах боломжтой.

$$dr = \bar{n} * D \quad (3)$$

Тайлбар: dr нь евро бондоор ногоон өрийн своп хэлцэл байгуулах тохиолдолд буурах гадаад

өрийн дүн

$\bar{n}$ нь бусад улс орнуудын гадаад өрийг хэмнэсэн дундаж хувь

D нь Монгол улс өрийн своп хэлцэлд ашиглах гадаад өрийн хэмжээ

$$\bar{n} = 1 - \sum_{i=1}^k PP_i / \sum_{i=1}^k UA_i \quad (4)$$

Тайлбар: PP_i нь i хэлцлээр UA_i хэмжээний бондыг худалдан авахад төлсөн мөнгөн дүн

UA_i нь i хэлцэлд ашигласан бондын нэрлэсэн үнийн нийт дүн

k нь тухайн төрлийн ногоон өрийн своп хэлцэл хийсэн нийт тоо

Өнгөрсөн хугацаанд хоёрдогч зах зээлээс гадаад өрийг худалдан авах замаар нийт 51 удаагийн 2.5 тэрбум ам.долларын үнийн дүнтэй ногоон өрийн своп хэлцлийн мэдээлэлд үндэслэн $\bar{n}$ үзүүлэлтийг тооцож Хүснэгт 4-д үзүүлэв. Монгол улсын засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан бүх евро бонд (2.0 тэрбум ам.долларын дүн бүхий)-ыг багцлан энэ төрлийн ногоон өрийн своп хэлцэл байгуулах тохиолдолд тэгшитгэл 3-ын дагуу Монгол улсын төрийн гадаад өр 1.1-1.7 тэрбум ам.доллар буюу 11-17 хувиар буурах боломжтой гэсэн тооцоолол гарлаа. Харин Парисын клубын улсууд болон БНХАУ-аас авсан гадаад зээлийг багцлан гурав дахь хувилбарын дагуу ногоон өрийн своп хэлцэл байгуулсан тохиолдолд төрийн гадаад өр 27 хүртэл хувиар буурах боломжтой гэсэн үр дүнг гарлаа.

Хүснэгт 4. Хоёрдогч зах зээлээс өрийг хямдруулж авсан хэлцлийн мэдээлэл

№	Хамрах хугацаа	Хямдруулсан хувь	Хэлцлийн үнийн дүн (сая.ам доллар)	Хэлцлийн тоо
1	Нийт	0.58	2,507	51
2	1980-2000	0.84	287	47
3	2001-2023	0.55	2,220	4

Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт

Мөн энэ төрлийн хэлцлийн хувьд Хүснэгт 3-д үзүүлсэн нийт хэлцлийн дунджаар $\bar{w}$ үзүүлэлтийг авч тэгшитгэл 1-н дагуу тооцоход 0.8-0.9 тэрбум ам.доллар буюу 2.5 - 2.9 их наяд төгрөгийн ногоон санхүүжилтийг бий болгох боломжтой байна.

Ийнхүү өрийн своп хэлцэл байгуулах нь нэг талаас уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, ногоон санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх, нөгөө талаас гадаад өрийн хэмжээг бууруулах давуу талтай байна. Засгийн газрын гадаад өрийн хэмжээ буурснаар өрийн дарамт багасах, зээлжих зэрэглэл сайжрах гэх зэргээр Монгол улсын макро эдийн засгийн эмзэг байдал буурах боломжтой юм.

V. Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлаар Монгол улс Парисын хэлэлцээрт нэгдэж, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг ногоон өрийн своп хэлцлээр санхүүжүүлэх боломжийг судаллаа. Ногоон өрийн своп нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөний эрсдэл өндөртэй, тэр хэрээр нөлөөг бууруулах, дасан зохицох төсөл, арга хэмжээнд санхүүжилт хийх шаардлагатай хэдий ч гадаад өрийн өндөр түвшнээс шалтгаалан төсвийн орон зай хязгаарлагдмал хөгжиж буй орнуудыг хувьд тохирох механизм болдог байна. 1980-аад оны сүүл 1990-ээд онд анхлан энэхүү ногоон өрийн свопыг өргөн ашигласан түүх нь Латин Америкийн улс орнууд өрийн хямралтай холбогддог. 2000 оноос түүний хэрэглээ хумигдсан хэдий ч 2020 оноос дахин анхаарлын төвд оржээ. Үүнд Ковид-19 цар тахал нөлөөлсөн ба гадаад өр өндөртэй хөгжиж буй орнууд цар тахлын эдийн засгийн хүндрэлийн нөлөөгөөр гадаад өрөө төлж чадахгүй эрсдэлтэй тулгарсан юм. Гадаад өр, төсвийн хүндрэлтэй байгаа хөгжиж буй орнууд давхар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, биологийн олон янз байдлын алдагдлын өндөр эрсдэлтэй тулгарсан байгаа нь энэ ногоон өрийн свопын ач холбогдол дахин өсөхөд хүргэсэн. Судлаачид ногоон өрийн своп хэлцлийн хэмжээг ахиулах, хэлцлийн зардлыг бууруулахын тулд улс орны хэмжээний КРІ тогтолцоо хөгжүүлэх; олон улсын өрийг хөнгөлөх, байгаль орчныг хамгаалах төслийг дэмжих бүтэц, байгууллагад нэгдэх; аль болох олон зээлдүүлэгчийг свопын хэлэлцээрт татан оролцуулах; байгаль орчны төсөл, үйл ажиллагаануудыг бодлого, хөтөлбөрийн дор багцлан своп хэлцэл хийх; зээлийн эргэн төлөлт, амлалтын бэрхшээлийг шийдэхийн тулд олон улсын санхүүгийн байгууллагаас баталгаа гаргуулах зэрэг бодлогын арга замыг зөвлөж байна.

Судалгаанд Монгол улс ногоон өрийн своп хэлцлийг Парисын клубын улс орнуудаас авсан гадаад зээлийг багцлах; БНХАУ-аас авсан гадаад өрөөр; Монгол улсын засгийн газрын евро бондуудыг багцлан хоёдогч зах зээлээс хямдруулан худалдан авах гэсэн 3 хувилбараар байгуулахад бий болох ногоон санхүүжилтийн хэмжээ, гадаад өрийн чөлөөлөгдөх хэмжээг олон улсын кейсд тулгуурлан авч үзлээ. Судалгааны үр дүнд дараах гол дүгнэлтэд хүрэв. Үүнд:

- Ногоон өрийн своп хэлцлийг Монгол улс бусад улсын жишгийн дагуу байгуулж чадсан тохиолдолд 2.2-6.5 их наяд төгрөгийн ногоон санхүүжилт буюу Парисын хэлэлцээрийг амжилттай биелүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн 20 гаруй хувийг бий болгох боломжтой.
- Мөн Парисын клубын улсууд болон БНХАУ-аас авсан гадаад зээлийг багцлан ногоон өрийн своп хэлцэл байгуулсан тохиолдолд төрийн гадаад өр 27 хүртэл хувиар буурах боломжтой байна.

VI. Ашигласан материал

Монгол хэл дээрх

- Монголбанк. (2023 оны 3 дугаар улирал). *Банкуудын ногоон зээлийн тайлан*. Улаанбаатар хот: Монголбанк.
- МУЗГ. (2019). *Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт*. Улаанбаатар.
- УИХ. (2020). *"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа*. Улаанбаатар.
- Мөнхзул, Б. (2024). *Өрийн Свон Хэрэгслийг Ашиглан Ногоон Санхүүжилтийн Эх Үүсвэрийг Нэмэгдүүлэх нь*. Улаанбаатар : Магистрын дипломын ажил. СЭЗИС

Англи хэл дээрх

- Aligishiev, Z., Bellon, M., & Massetti, E. (2022). Macro-Fiscal Implications of Adaptation to Climate Change. *IMF Staff Climate Note 2022/002*.
- African Natural Resources Management and Investment (2022). *Debt for Nature Swaps – Feasibility and Policy Significance in Africa's Natural Resources Sector*. Abidjan, Côte d'Ivoire: African Development Bank.
- Chamon, M. d., Klok, E., Thakoor, V. V., & Zettelmeyer, J. (2022). Debt-for-Climate Swaps as a Tool to Support the Implementation of the Paris Agreement. *IMF Working Papers*.
- Chamon, M., Klok, E., Thakoor, V., & Zettelmeyer, J. (2022). *"Debt-for-Climate Swaps: Analysis, Design, and Implementation"*. Washington, DC: International Monetary Fund.
- Climate Policy Initiative. (2023). *Global Landscape of Climate Finance 2023*. San Francisco: Climate Policy Initiative.
- COP28 (2023). Debt-for-Climate Swaps: A Tool to Supporting the Implementation of the Paris Agreement [A. Sabry, B. Li, F. Rijsberman, & E. Grigoryan бичигдсэн]. Dubai, United Arab Emirates.
- Georgieva, K., Gaspar, V., & Pazarbasioglu, C. (2022 оны March 23). *Poor and Vulnerable Countries Need Support to Adapt to Climate Change*. IMF Blog: <https://www.imf.org/en/Blogs/Articles/2022/03/23/blog032322-poor-and-vulnerable-countris-need-support-to-adapt-to-climate-change>-ээс Гаграсан
- Grigoryan, E., Alberto, I., & Patrick, M. J. (2022). Debt for climate swaps in the Pacific SIDS. *MPFD Policy Brief, No. 123*. Bangkok: ESCAP.
- IMF. (2023). *Mongolia: Staff Report for the 2023 Article IV Consultation*. Washington, D.C: International Monetary Fund.
- Jones et all. (2023). National contributions to climate change. *Population based on various sources with major processing by Our World in Data*.
- Karaki, K., Medinilla, A., & Bilal, S. (2023). *Three ways to scale up debt-for-climate swaps*. Maastricht : ECDPM.
- Knicley, J. (2012). Debt, nature, and indigenous rights: Twenty-five years of Debt-For-Nature Evolution. *Harvard Environmental Law Review*.
- Kummer, S., & Pauletto, C. (2011). The History of Derivatives: A Few Milestones. *EFTA Seminar on Regulation of Derivatives Markets*. Zurich: Federal Department of Economic Affairs FDEA.

- Ministry of Environment and Tourism of Mongolia. (2018). *Third National Communication of Mongolia under the UNFCCC*. Ulaanbaatar.
- OECD. (2007). *Lessons Learnt from Experience with Debt-for-Environment Swaps in Economies in Transition*. Paris: OECD Publishing.
- Owen, N. (2022). Belize: Swapping Debt for Nature. *IMF, Finance & Development Magazine*, March 2022 Issue.
- Paris Club. (2020 оны 6 20). *The Paris Club Releases Comprehensive Data on its Claims as of 31*
- Steele, P., & Patel, S. (2020). *Tackling the triple crisis: Using debt swaps to address debt, climate and nature loss post-COVID-19*. London: IIED.
- Steele, P., Kelly, L., Ducros, A., & Patel, S. (2022). *Debt Swaps for Climate and Nature*. The International Institute for Environment and Development.
- Swanson, E., Niu, R., Zhu, L., Wang, C., & Yue, M. (2022). *Debt for Nature Swap: A Green Finance Tool for Dealing with Overseas Sovereign Debt*. Beijing: Paulson Institute & Green Finance and Development Center, Fudan University.
- Worldbank, & ABD. (2021). *Climate Risk Country Profile: Mongolia*.
- WWF. (2021). *NDC Checklist: Mongolia Analysis*. WWF.
- Yue, M., & Wang, C. N. (2021). *Debt-For-Nature Swaps: A Triple-Win Solution for Debt Sustainability and Biodiversity Finance in Belt and Road Initiative (BRI)?* Beijing: IIGF Green BRI Cente.

ХАВСРАЛТ 1. СУДАЛГААНД АШИГЛАСАН ӨРИЙН СВОП ХЭЛЦЛИЙН ӨГӨГДӨЛ

№	Улс	Хэлцлийн огноо	Төрөл	Хэлцэлд оролцогч тал	Өрийн хэмжээ	Босгосон ногоон санхүүжилт	Өрийг хямдруулан авсан үнийн дүн	Зээлдүүлэгчийн төрөл
1	Боливи	1987	Олон талт	Q, Frank Weeden Foundation	\$650,000	\$250,000	\$100,000	Бусад
2	Екуадор	1987	Олон талт	WWF, Frank Weeden Foundation	\$1,000,000	\$1,000,000	\$354,000	Бусад
3	Коста Рика	1988	Олон талт	National Parks Foundation, Association Ecological La Pacifica, Q, J.S. Noyes Foundation, MacArthur Foundation, TNC, Organization for Tropical Studies, Pew Charitable Trusts, Swedish Society for the Conservation of Nature, W. Alton Jones Foundation, WWF	\$5,400,000	\$4,050,000	\$918,000	Бусад
4	Коста Рика	1988	Олон талт	Netherlands	\$33,000,000	\$9,900,000	\$5,000,000	Парисын клуб
5	Филиппины	1988	Олон талт	WWF	\$390,000	\$390,000	\$195,975	Бусад
6	Коста Рика	1989	Олон талт	TNC	\$5,600,000	\$1,680,000	\$784,000	Бусад
7	Коста Рика	1989	Олон талт	Sweden	\$24,500,000	\$17,150,000	\$3,500,000	Парисын клуб
8	Екуадор	1989	Олон талт	TNC, Missouri Botanical Garden	\$3,600,000	\$3,600,000	\$424,080	Бусад
9	Екуадор	1989	Олон талт	WWF	\$5,389,473	\$5,389,473	\$640,000	Бусад
10	Мадагаскар	1989	Олон талт	WWF, USAID	\$2,111,112	\$2,111,112	\$950,000	Бусад
11	Замбия	1989	Олон талт	WWF, Anonymous Swiss donor	\$2,271,112	\$2,044,001	\$454,222	Бусад
12	Коста Рика	1990	Олон талт	Sweden, TNC, WWF	\$10,800,000	\$9,600,000	\$1,900,000	Бусад
13	Доминикан Республика	1990	Олон талт	TNC, Puerto Rico Conservation Trust	\$582,000	\$582,000	\$116,000	Бусад
14	Мадагаскар	1990	Олон талт	WWF	\$919,364	\$919,364	\$445,891	Бусад
15	Филиппины	1990	Олон талт	WWF, USAID	\$900,000	\$900,000	\$438,750	Бусад
16	Польш	1990	Олон талт	WWF	\$50,000	\$50,000	\$11,500	Бусад
17	Польш	1990	Хоёр талт	Finland	\$17,000,000	\$17,000,000	N/A	Парисын клуб
18	Боливи	1991	Хоёр талт	USA	\$30,700,000	\$21,800,000	N/A	Парисын клуб
19	Чили	1991	Хоёр талт	USA	\$15,900,000	\$1,400,000	N/A	Парисын клуб
20	Коста Рика	1991	Олон талт	TNC, Rainforest Alliance	\$600,000	\$540,000	\$360,000	Бусад
21	Гватемала	1991	Олон талт	TNC	\$100,000	\$90,000	\$75,000	Бусад
22	Ямайка	1991	Олон талт	Puerto Rico Conservation Trust, TNC, USAID	\$437,956	\$437,956	\$300,000	Бусад
23	Ямайка	1991	Хоёр талт	USA	\$216,700,000	\$9,200,000	N/A	Парисын клуб
24	Мадагаскар	1991	Олон талт	Q, UNDP	\$119,000	\$119,000	\$59,000	Бусад
25	Мексико	1991	Олон талт	Q, Sequoia Foundation, MacArthur Foundation	\$250,000	\$250,000	\$183,000	Бусад
26	Мексико	1991	Олон талт	Q	\$250,000	\$250,000	N/A	Бусад
27	Нигерия	1991	Олон талт	Nigeria Conservation Foundation	\$149,000	\$93,000	\$65,000	Бусад
28	Парагвай	1991	Олон талт	TNC, USAID, Applied Energy Services	\$9,000,000	\$5,000,000	\$2,000,000	Бусад
29	Польш	1991	Хоёр талт	USA	\$370,000,000	\$370,000,000	N/A	Парисын клуб
30	Бразил	1992	Олон талт	TNC, American Express Foundation, Second Nature Software	\$2,192,000	\$2,192,000	\$746,000	Бусад
31	Чили	1992	Хоёр талт	USA	\$14,700,000	\$17,300,000	N/A	Парисын клуб
32	Колумбия	1992	Хоёр талт	USA	\$31,000,000	\$41,600,000	N/A	Парисын клуб
33	Египет	1992	Хоёр талт	France	\$0	\$11,600,000	N/A	Парисын клуб
34	Эл Сальвадор	1992	Хоёр талт	USA	\$268,400,000	\$25,600,000	N/A	Парисын клуб
35	Эл Сальвадор	1992	Хоёр талт	USA	\$195,500,000	\$15,600,000	N/A	Парисын клуб
36	Гана	1992	Олон талт	Q, International Council on Monuments and Sites, Midwest Universities Consortium for International Activities, Smithsonian Institution, USAID	\$1,000,000	\$1,000,000	\$250,000	Бусад
37	Гватемала	1992	Олон талт	Q, USAID	\$1,300,000	\$1,300,000	\$1,200,000	Бусад
38	Мексико	1992	Олон талт	Q, USAID	\$441,000	\$441,000	\$355,000	Бусад
39	Филиппины	1992	Олон талт	WWF, USAID	\$9,646,606	\$8,815,946	\$5,000,000	Бусад
40	Филиппины	1992	Хоёр талт	France	\$0	\$4,000,000	N/A	Парисын клуб
41	Тунис	1992	Хоёр талт	Sweden	\$1,342,000	\$1,342,000	N/A	Парисын клуб
42	Уругвай	1992	Хоёр талт	USA	\$400,000	\$90,000	N/A	Парисын клуб
43	Уругвай	1992	Хоёр талт	USA	\$3,300,000	\$6,100,000	N/A	Парисын клуб
44	Аргентина	1993	Хоёр талт	USA	\$3,800,000	\$3,100,000	N/A	Парисын клуб
45	Боливи	1993	Хоёр талт	Belgium	\$13,000,000	\$0	N/A	Парисын клуб
46	Боливи	1993	Олон талт	TNC, WWF, Morgan Guaranty Trust Co.	\$11,465,795	\$2,816,400	\$0	Бусад
47	Боливи	1993	Хоёр талт	Sweden	\$35,400,000	\$3,900,000	N/A	Парисын клуб
48	Боливи	1993	Хоёр талт	Switzerland	\$35,400,000	\$1,365,000	N/A	Парисын клуб
49	Колумбия	1993	Хоёр талт	Canada	\$12,000,000	\$12,000,000	N/A	Парисын клуб
50	Египет	1993	Хоёр талт	Norway	\$17,300,000	\$0	N/A	Парисын клуб

№	Улс	Хэлцлийн огноо	Төрөл	Хэлцэлд оролцогч тал	Өрийн хэмжээ	Босгосон ногоон санхүүжилт	Өрийг хямдруулан авсан үнийн дүн	Зээлдүүлэг- чийн төрөл
51	᠓Egy pt	1993	Хоёр талт	Norw ay	\$6,200,000		\$0 NA	Парисын клуб
52	᠓El Salv ador	1993	Хоёр талт	Canada	\$7,500,000	\$6,000,000	NA	Парисын клуб
53	᠓Honduras	1993	Хоёр талт	Canada	\$24,900,000	\$12,450,000	NA	Парисын клуб
54	᠓Honduras	1993	Хоёр талт	Sw itz erland	\$42,030,000	\$8,430,000	NA	Парисын клуб
55	᠓Jamaica	1993	Хоёр талт	USA	\$94,100,000	\$12,300,000	NA	Парисын клуб
56	᠓Madagascar	1993	Олон талт	CI, USAID	\$3,200,000	\$3,200,000	\$1,500,000	Бусад
57	᠓Madagascar	1993	Олон талт	WWF, USAID	\$3,735,000	\$1,867,500	\$1,818,824	Бусад
58	᠓Madagascar	1993	Олон талт	Missouri Botanical Garden	\$725,000	\$725,000	\$362,500	Бусад
59	᠓Mexico	1993	Олон талт	CI	\$252,000	\$252,000	\$208,000	Бусад
60	᠓Nicaragua	1993	Хоёр талт	Canada	\$13,600,000	\$2,700,000	NA	Парисын клуб
61	᠓Nigeria	1993	Хоёр талт	UK	\$7,300,000		\$0 NA	Парисын клуб
62	᠓Nigeria	1993	Хоёр талт	Norw ay	\$10,200,000		\$0 NA	Парисын клуб
63	᠓Peru	1993	Хоёр талт	Sw itz erland	\$131,000,000	\$32,700,000	NA	Парисын клуб
64	᠓Philippines	1993	Олон талт	WWF, USAID	\$19,000,000	\$17,100,000	\$12,973,854	Бусад
65	᠓Poland	1993	Хоёр талт	France	\$66,000,000	\$66,000,000	NA	Парисын клуб
66	᠓Poland	1993	Хоёр талт	Sw itz erland	\$63,000,000	\$63,000,000	NA	Парисын клуб
67	᠓Tanzania	1993	Хоёр талт	UK	\$15,400,000	\$15,400,000	NA	Парисын клуб
68	᠓Tanzania	1993	Хоёр талт	Sw itz erland	\$25,600,000	\$190,000	NA	Парисын клуб
69	᠓Tunisia	1993	Хоёр талт	Sw eden	\$477,300	\$477,300	NA	Парисын клуб
70	᠓Ecuador	1994	Хоёр талт	Sw itz erland	\$46,390,000	\$4,524,000	NA	Парисын клуб
71	᠓Madagascar	1994	Олон талт	WWF, Deutschebank	\$1,340,469	\$1,072,376	NA	Бусад
72	᠓Madagascar	1994	Олон талт	CI	\$200,000	\$160,000	\$50,000	Бусад
73	᠓Mexico	1994	Олон талт	CI	\$280,000	\$280,000	\$236,000	Бусад
74	᠓Mexico	1994	Олон талт	CI	\$480,000	\$480,000	\$399,390	Бусад
75	᠓Mexico	1994	Олон талт	CI	\$290,000	\$290,000	\$248,395	Бусад
76	᠓Zambia	1994	Олон талт	IUCN - World Conservation Union	\$985,986	\$162,687	\$108,458	Бусад
77	᠓Bulgaria	1994	Хоёр талт	Sw itz erland	\$16,700,000	\$16,200,000	NA	Парисын клуб
78	᠓Costa Rica	1995	Хоёр талт	Canada	\$16,600,000	\$8,300,000	NA	Парисын клуб
79	᠓Egy pt	1995	Хоёр талт	Sw itz erland	\$121,000,000	\$18,000,000	\$246,000	Парисын клуб
80	᠓Guinea-Bissau	1995	Хоёр талт	Sw itz erland	\$8,400,000	\$400,000	NA	Парисын клуб
81	᠓Jordan	1995	Хоёр талт	Germany	\$13,400,000	\$6,700,000	NA	Парисын клуб
82	᠓Jordan	1995	Хоёр талт	Germany	\$22,700,000	\$11,300,000	NA	Парисын клуб
83	᠓Mexico	1995	Олон талт	CI, USAID	\$48,800	\$336,500	NA	Бусад
84	᠓Peru	1995	Хоёр талт	Canada	\$17,036,160	\$354,920	NA	Парисын клуб
85	᠓Peru	1995	Хоёр талт	Germany	\$20,150,000	\$6,089,309	NA	Парисын клуб
86	᠓Philippines	1995	Хоёр талт	Sw itz erland	\$16,100,000	\$16,100,000	NA	Парисын клуб
87	᠓Costa Rica	1996	Хоёр талт	Netherlands	\$14,100,000	\$14,100,000	NA	Парисын клуб
88	᠓Madagascar	1996	Олон талт	WWF, DGIS (Netherlands Development Cooperation)	\$2,000,000	\$1,500,000	NA	Бусад
89	᠓Mexico	1996	Олон талт	CI	\$391,000	\$254,000	\$191,607	Бусад
90	᠓Mexico	1996	Олон талт	CI	\$495,674	\$442,622	\$327,393	Бусад
91	᠓Mexico	1996	Олон талт	CI	\$670,889	\$560,752	\$440,360	Бусад
92	᠓Peru	1996	Хоёр талт	Finland	\$24,618,409	\$6,154,516	NA	Парисын клуб
93	᠓Philippines	1996	Хоёр талт	Germany	\$5,800,000	\$1,800,000	NA	Парисын клуб
94	᠓Vietnam	1996	Хоёр талт	Germany	\$18,200,000	\$5,400,000	NA	Парисын клуб
95	᠓Bolivia	1997	Хоёр талт	Germany	\$3,700,000	\$1,150,000	NA	Парисын клуб
96	᠓Mexico	1997	Олон талт	CI	\$265,714	\$243,494	\$186,000	Бусад
97	᠓Mexico	1997	Олон талт	CI	\$310,000	\$299,499	\$237,661	Бусад
98	᠓Peru	1997	Хоёр талт	USA	\$177,000,000	\$22,800,000	NA	Парисын клуб
99	᠓Poland	1997	Хоёр талт	Sw eden	\$13,000,000	\$13,000,000	NA	Парисын клуб
100	᠓Mexico	1998	Олон талт	CI	\$311,000	\$311,000	\$249,000	Бусад

№	Улс	Хэлцлийн огноо	Төрөл	Хэлцэлд оролцогч тал	Өрийн хэмжээ	Босгосон ногоон санхүүжилт	Өрийг хямдруулан авсан үнийн дүн	Зээлдүүлэг- чийн төрөл
101	Poland	1998	Хоёр талт	Italy	\$32,000,000	\$32,000,000	NA	Парисын клуб
102	Costa Rica	1999	Хоёр талт	Spain	\$5,222,000	\$2,180,000	NA	Парисын клуб
103	Honduras	1999	Хоёр талт	Germany	\$1,068,000	\$534,000	NA	Парисын клуб
104	Peru	1999	Хоёр талт	Germany	\$4,968,203	\$1,987,281	NA	Парисын клуб
105	Peru	1999	Хоёр талт	Germany	\$4,968,203	\$1,987,281	NA	Парисын клуб
106	Vietnam	1999	Хоёр талт	Germany	\$16,400,000	\$5,000,000	NA	Парисын клуб
107	Bangladesh	2000	Хоёр талт	USA	\$10,000,000	\$8,100,000	NA	Парисын клуб
108	Bolivia	2000	Хоёр талт	Germany	\$15,800,000	\$3,200,000	NA	Парисын клуб
109	Ghana	2000	Олон талт	CI	\$120,000	\$120,000	\$104,000	Бусад
110	Jordan	2000	Хоёр талт	Germany	\$43,600,000	\$21,800,000	NA	Парисын клуб
111	Poland	2000	Хоёр талт	Norway	\$27,000,000	\$27,000,000	NA	Парисын клуб
112	Belize	2001	Хоёр талт	USA	\$9,700,000	\$9,000,000	NA	Парисын клуб
113	Egypt	2001	Хоёр талт	Italy	\$7,450,000	\$7,450,000	NA	Парисын клуб
114	El Salvador	2001	Хоёр талт	USA	\$7,700,000	\$14,000,000	NA	Парисын клуб
115	Jordan	2001	Хоёр талт	Germany	\$11,300,000	\$5,700,000	NA	Парисын клуб
116	Syria	2001	Хоёр талт	Germany	\$31,700,000	\$15,900,000	NA	Парисын клуб
117	Vietnam	2001	Хоёр талт	Germany	\$7,000,000	\$0	NA	Парисын клуб
118	Ecuador	2002	Хоёр талт	Germany	\$9,500,000	\$3,081,000	\$5,500,000	Парисын клуб
119	Ecuador	2002	Хоёр талт	Germany	\$10,200,000	\$3,235,000	NA	Парисын клуб
120	Peru	2002	Олон талт	WWF, CI, TNC, USA	\$28,315,096	\$10,604,003	NA	Бусад
121	Philippines	2002	Хоёр талт	USA	\$5,500,000	\$8,300,000	NA	Парисын клуб
122	Madagascar	2003	Хоёр талт	Germany	\$25,092,000	\$14,843,000	NA	Парисын клуб
123	Panama	2003	Хоёр талт	USA	\$10,000,000	\$10,000,000	NA	Парисын клуб
124	Peru	2003	Хоёр талт	Germany	\$25,000,002	\$7,500,000	NA	Парисын клуб
125	Colombia	2004	Хоёр талт	USA	\$7,000,000	\$10,000,000	NA	Парисын клуб
126	Jamaica	2004	Хоёр талт	USA	\$6,500,000	\$16,000,000	NA	Парисын клуб
127	Panama	2004	Хоёр талт	USA	\$6,500,000	\$10,900,000	NA	Парисын клуб
128	Botswana	2006	Хоёр талт	USA	\$8,300,000	\$10,000,000	NA	Парисын клуб
129	Cameroon	2006	Хоёр талт	France	\$0	\$25,000,000	NA	Парисын клуб
130	Guatemala	2006	Хоёр талт	USA	\$15,000,000	\$24,000,000	NA	Парисын клуб
131	Indonesia	2006	Хоёр талт	Germany	\$10,915,160	\$5,019,380	NA	Парисын клуб
132	Indonesia	2006	Хоёр талт	Germany	\$10,915,160	\$5,019,380	NA	Парисын клуб
133	Paraguay	2006	Хоёр талт	USA	\$4,800,000	\$7,400,000	NA	Парисын клуб
134	Costa Rica	2007	Хоёр талт	USA	\$12,600,000	\$26,100,000	NA	Парисын клуб
135	Peru	2008	Хоёр талт	USA	\$19,600,000	\$25,000,000	NA	Парисын клуб
136	Indonesia	2009	Хоёр талт	USA	\$29,900,000	\$29,900,000	NA	Парисын клуб
137	Brazil	2010	Хоёр талт	USA	\$21,000,000	\$21,000,000	NA	Парисын клуб
138	Costa Rica	2010	Хоёр талт	USA	\$21,000,000	\$27,000,000	NA	Парисын клуб
139	Indonesia	2011	Хоёр талт	USA	\$28,500,000	\$28,500,000	NA	Парисын клуб
140	Philippines	2013	Хоёр талт	USA	\$28,200,000	\$31,800,000	NA	Парисын клуб
141	Indonesia	2014	Хоёр талт	USA	\$11,200,000	\$12,700,000	NA	Парисын клуб
142	Mozambique	2014	Хоёр талт	Germany	\$0	\$7,536,020	NA	Парисын клуб
143	Mozambique	2015	Хоёр талт	France	\$15,779,733	\$1,803,398	NA	Парисын клуб
144	Seychelles	2015	Олон талт	TNC et. AI	\$29,600,000	\$6,600,000	\$28,000,000	Бусад
145	Belize	2021	Олон талт	TNC	\$552,900,000	\$23,000,000	\$304,095,000	Бусад
146	Ecuador	2023	Олон талт	Credit Suisse, IADB, U.S. IDFC	\$1,628,000,000	\$550,000,000	\$656,000,000	Бусад